



## БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Халамжийн сан/УТ/ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/1/СТА-ЗГТС

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас:7044-2584 Цахим хаяг:munkhbat@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 7044-242 Цахим хаяг:tsegtsegmaad@audit.gov.mn

Аудитор: Ж.Чогсомжанлав

Утас:99080969 Цахим хаяг:chogsom83@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

|          |                                                                |
|----------|----------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын<br>Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт                  |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                    |

## Агуулга

---

|         |                                                                                                               |                                     |
|---------|---------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------|
| 1       | Аудитын гэрчилгээ .....                                                                                       | 3                                   |
| 2       | Аудитын тайлан.....                                                                                           | 4                                   |
| 2.1.    | Оршил.....                                                                                                    | 4                                   |
| 2.2.    | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....                                         | 4                                   |
| 2.3.    | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....                                         | 5                                   |
| 2.4.    | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....                                              | 5                                   |
| 2.5.    | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 2.6.    | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....                                         | 6                                   |
| 2.7.    | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....                                                    | 7                                   |
| 2.8.    | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....                                                   | 7                                   |
| 2.8.1   | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар .....     | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 2.8.2   | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар.....               | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 2.8.2.1 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал..                                       | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 2.9.    | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....                                  | 7                                   |
| 2.10.   | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....                                                          | 7                                   |
| 2.11.   | Шилэн дансны мэдээлэл .....                                                                                   | 8                                   |
| 2.12.   | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....                                                | 8                                   |
| 2.13.   | Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:                                                  | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 2.14    | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....                                                                       | 8                                   |
| 3       | Менежментийн захидал.....                                                                                     | 9                                   |
| 4       | Аудит хийсэн санхүүгийн тайлан.....                                                                           | 9                                   |

## **1 Аудитын гэрчилгээ**

---

*Батлагдсан гэрчилгээ скайннердаж энд оруулах*

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Баянхонгор аймгийн Халамжийн сан/УТ/ 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч ХХҮГ-ын дарга Амарсанаа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Баянхонгор аймгийн Халамжийн сан/УТ/ 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Халамжийн сан/УТ/ 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.10-наас 2019.01.17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.01.31-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын гэрээт аудитор Ж.Чогсомжанлав хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Халамжийн сан/УТ/ 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.01.09-ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Халамжийн сан/УТ/-гийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Халамжийн сан/УТ/ нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй, чанар хүртээмжтэй хүргэхэд халамж, асрамжийн үйлчилгээг хуулийн хүрээнд зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог ханган хамтран ажиллах, хувиарлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зөв зарцуулах шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, анхан шатны нэгжид ажиллаж байгаа ажилтнуудыг арга зүйн удирдлагаар хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор аймгийн Халамжийн сан/УТ/-гийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлж иргэдийг ажилтай орлоготой болгох.
- Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэд болон зорилтод бүлгийн иргэдийн талаар төрөөс баримтлах бодлого шийдвэр хууль тогтоомжийн хэрэгжилт хангах

Баянхонгор аймгийн Халамжийн сан/УТ/-гийн удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Халамжийн сан /УТ/-гийн санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 45 оноо авсан тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитод татан оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Халамжийн сан /УТ/- нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Finance” програм хангамж ашиглаж байна.

Баянхонгор аймгийн Халамжийн сан/УТ/-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Баянхонгор аймгийн Халамжийн сан/УТ/-гийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг

баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд Баянхонгор аймгийн Халамжийн сан /УТ/-гийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж санал дүгнэлт гаргахад шаардлагатай материаллаг байдлын түвшинг урьдчилсан байдлаар тооцохдоо суурь үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгох нь зохимжтой гэж үзэв.

Гүйцэтгэлийн явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

Баянхонгор аймгийн Халамжийн сан/УТ/ 2018 оны *Нийт зардал* 4,713,271.1 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 4,713,271.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоож, Маягт №Б201-ээр баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилыг хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв. Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа зөрчил илрээгүй, залруулга хийгдээгүй болно.

Аудитын явцад залруулга хийгдээгүй болно.

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Халамжийн сан/УТ/-гийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 5-н санд 2018 онд 4,711,094.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ.



Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 4,667,742,1 мянган төгрөг буюу 99.1 хувьтай, байна.

#### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Баянхонгор аймгийн Халамжийн сан/УТ/, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

#### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

#### **2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Баянхонгор аймгийн Халамжийн сан /УТ/-гийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Халамжийн сан /УТ/-гийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Тус байгууллагын аудитын тайлангаар, менежментийн захидал өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

#### 4.1 САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт                                           | Өмнөх оны гүйцэтгэл     | Тайлант оны гүйцэтгэл   |
|------------|----------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>             | <b>1,641,420,139.23</b> | <b>4,713,271,899.30</b> |
| 12         | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                         | <b>6,780,139.23</b>     | <b>6,621,899.30</b>     |
| 120        | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                 | 6,780,139.23            | 6,621,899.30            |
| 120002     | Хүүгийн орлого                                     | 2,610,139.23            | 3,941,899.30            |
| 120009     | Бусад орлого                                       | 4,170,000.00            | 2,680,000.00            |
| 13         | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>               | <b>1,634,640,000.00</b> | <b>4,706,650,000.00</b> |
| 1310       | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                     | 1,634,640,000.00        | 4,706,650,000.00        |
| 131001     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                  | 1,634,640,000.00        | 4,706,650,000.00        |
| 2          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                 | <b>1,641,420,139.23</b> | <b>4,713,271,899.30</b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                               | <b>1,641,420,139.23</b> | <b>4,713,271,899.30</b> |
| 213        | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                            | 1,641,420,139.23        | 4,713,271,899.30        |
| 2132       | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                      | 1,589,612,170.00        | 4,667,742,100.00        |
| 213203     | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж               | 1,589,612,170.00        | 4,667,742,100.00        |
| 2133       | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b> | 51,807,969.23           | 45,529,799.30           |
| 213303     | Төвлөрүүлэх шилжүүлэг                              | 51,807,969.23           | 45,529,799.30           |

## 4.2 МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код  | Үзүүлэлт                                                        | Өмнөх оны гүйцэтгэл            | Тайлант оны гүйцэтгэл          |
|-------------|-----------------------------------------------------------------|--------------------------------|--------------------------------|
|             | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                           |                                |                                |
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>                   | <b><u>1,641,420,139.23</u></b> | <b><u>4,722,803,899.30</u></b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                                      | <b>6,780,139.23</b>            | <b>16,153,899.30</b>           |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                              | 6,780,139.23                   | 16,153,899.30                  |
| 120002      | Хүүгийн орлого                                                  | 2,610,139.23                   | 3,941,899.30                   |
| 120004      | <b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>                         | 4,030,000.00                   | 9,532,000.00                   |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                       | 4,030,000.00                   | 9,532,000.00                   |
| 120009      | Бусад орлого                                                    | 140,000.00                     | 2,680,000.00                   |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                            | <b>1,634,640,000.00</b>        | <b>4,706,650,000.00</b>        |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                                  | 1,634,640,000.00               | 4,706,650,000.00               |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                               | 1,634,640,000.00               | 4,706,650,000.00               |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>                    | <b><u>1,641,420,491.10</u></b> | <b><u>4,722,803,899.30</u></b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                            | <b>1,641,420,491.10</b>        | <b>4,722,803,899.30</b>        |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                          | <b>680,000.00</b>              | -                              |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | 680,000.00                     | -                              |
| 210818      | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/                                     | 680,000.00                     | -                              |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                         | <b>1,640,740,491.10</b>        | <b>4,722,803,899.30</b>        |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                   | 1,588,932,170.00               | 4,677,274,100.00               |
| 213203      | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж                            | 1,588,932,170.00               | 4,677,274,100.00               |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>              | 51,808,321.10                  | 45,529,799.30                  |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг                                           | 51,808,321.10                  | 45,529,799.30                  |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>         | <b><u>(351.87)</u></b>         | <b>=</b>                       |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                | <b>(351.87)</b>                | <b>-</b>                       |
| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>         | 351.87                         | -                              |

## ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт                                         | Өмнөх оны             |                 | Тайлант оны           |                 |
|-----------------------|--------------------------------------------------|-----------------------|-----------------|-----------------------|-----------------|
|                       |                                                  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл       | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл       |
| 1                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл |                       |                 |                       |                 |
| 2                     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                | 1,647,040,000.0       | 1,585,582,170.0 | 4,711,094,490.0       | 4,667,742,100.0 |
| 21                    | УРСГАЛ ЗАРДАЛ                                    | 1,647,040,000.0       | 1,585,582,170.0 | 4,711,094,490.0       | 4,667,742,100.0 |
| 213                   | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                 | 1,647,040,000.0       | 1,585,582,170.0 | 4,711,094,490.0       | 4,667,742,100.0 |
| 2132                  | Бусад урсгал шилжүүлэг                           | 1,647,040,000.0       | 1,585,582,170.0 | 4,711,094,490.0       | 4,667,742,100.0 |
| 213203                | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж             | 1,647,040,000.0       | 1,585,582,170.0 | 4,711,094,490.0       | 4,667,742,100.0 |
|                       | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                   | 1,647,040,000.0       | 1,585,582,170.0 | 4,711,094,490.0       | 4,667,742,100.0 |
| 1310                  | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                          | 1,647,040,000.0       | 1,585,582,170.0 | 4,711,094,490.0       | 4,667,742,100.0 |
| 131001                | Улсын төсвөөс санхүүжих                          | 1,647,040,000.0       | 1,585,582,170.0 | 4,711,094,490.0       | 4,667,742,100.0 |